



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/13

Улаанбаатар хот

“Улаанбаатар өвлийн наадам 2017”
арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 5/10 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн Эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1.4.6, 1.4.9, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.5, 1.4.6, 1.4.9 дэх заалт, газрын дүрмийн 2.5.3, 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах зорилгоор “Улаанбаатарын өвлийн наадам 2017” арга хэмжээг 2017 оны 02 дугаар сарын 11,12-ны өдөр Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулахыг Бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Э.Батжаргал/-д үүрэг болгосугай.

2. “Улаанбаатарын өвлийн наадам 2017” арга хэмжээг зохион байгуулах ажилд шаардагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

3. “Улаанбаатарын өвлийн наадам 2017” арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах төсөв болох 51 236 000 /Тавин нэгэн сая хоёр зуун гучин зургаан мянга/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг ахлах нягтлан бодогч /Г.Цэрэннадмид/-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

D. Batsum

Д.БАТСҮХ



1150500043

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2017 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/13 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**“УЛААНБААТАРЫН ӨВЛИЙН НААДАМ 2017” АРГА ХЭМЖЭЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ**

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
Мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр				
1	“Ленин” клуб хажууд байрлуулах, анонс хэвлүүлэх, тогтоолт	6*12м	12 375	891 000
2	“Ленин” клубын хажууд байрлуулах самбарын түрээс	5 хоног	150 000	750 000
3	Тайзны анонс хэвлүүлэх	8м*8м	6250	400 000
4	Тайзны хормойн анонс	8м*1,2м	16 000	160 000
5	Нугалбар /ерөнхий мэдээлэл/	A4 6000ш	500	3 000 000
6	ҮЦХ-н самбарт слайд хэвлүүлэх	2,3м*1,3м 4ш	20 000	240 000
7	Зохион байгуулагчдын мандатын зардал	50	1500	75 000
8	Хэвлэлийн дизайны эх бэлтгэл, сурталчилгааны шторк хийлгэх	20 сек	3 000 000	3 000 000
9	ТВ форматад оруулан, нэвтрүүлэг бэлтгүүлэх	багц	3 500 000	3 500 000
10	Сурталчилгааны хуудас хэвлүүлэх	700	2000	1 400 000
Дүн				13 416 000
Зохион байгуулалтын чиглэлээр				
11	Мөсөн сурын зохион байгуулалт, тэмцээний урамшуулал	Тэмцээний урамшуулал	1-р байр 300 000	870 000
			2-р байр 200 000	
			3-р байр 100 000	
		Зохион байгуулалт+ сонирхогч тэмцээн	270 000	
Мөсөн шагай		10 хүн	100 000	1 000 000
12	Рагби+ зохион байгуулалтын зардал	Тэмцээний шагнал	1-р байр 300 000	1 066 000
			2-р байр 200 000	

			3-р байр 100 000	
		24ш медаль	24*4000= 96000	
		Цом 1ш	100 000	
		Шүүгч 10*20 000	270 000	
13	Мөсөн шатар	2 хүн	100 000	200 000
14	Урлагийн тоглолт	2 өдөр	1 500 000	3 000 000
15	Хөтлөгчийн хөлс	1 хүн Англи, монгол хэлээр хөтөлнө	2 000 000	2 000 000
16	Уран бүтээлчдийг тээвэрлэх автобус түрээслэх	2 өдөр	150 000	300 000
17	Хөгжим, техник хэрэгсэл, техникийн ажилтан, тайз түрээслэх, чимэглэл	2 өдөр	2 500 000	5 000 000
18	Параглайдингийн үзүүлбэр	2 өдөр /2хүн/	500 000	1 000 000
19	Өвлийн дугуйн тээвэрлэлтийн хөлс	2 өдөр	60 000	120 000
20	Нохойтой чарганы тээвэрлэлтийн хөлс	4 удаа	125 000	500 000
21	Мини амьтны хүрээлэн /40 төрлийн 100 амьтдын тээврийн зардал, угсардаг үүр, сав хийх/	Тээвэрлэлт	1 000 000	1 000 000
22	Зохион байгуулагчдын ус, хоол, унааны мөнгө	30 хүн	15 000	450 000
23	Шагнал, шүүгчдийн зардал -Цасан урлал гэр бүлийн буухиа тэмцээн -Гэр бүлийн буухиа -Дэгжин хувцастай оролцогчийн урамшуулал	багц	3 000 000	3 000 000
Дүн				19 506 000
Талбайн тохижилтын ажил				
24	Мөсөн хана бэлтгэх	багц	3 000 000	3 000 000
25	Сноубоардын талбай бэлтгэх, тэмцээн уралдаан зохион байгуулалтын зардал	багц	2 000 000	2 000 000
26	Мөсөн гулгуур, тэшүүрийн талбай хийх	багц	2 778 000	2 778 000
27	Мөсөн шатар хийх гадна талбайн тохижилт	багц	4 500 000	4 500 000
28	Цэвэрлэгээ, зөөврийн бие засах газрууд тээвэрлэх, байрлуулах, цахилгаан, ус цас зөөх	багц	2 000 000	2 000 000

29	Гэр түрээслэх	5ш	150 000	750 000
30	Асар түрээслэх	20	164 300	3 286 000
	Дүн			18 314 000
	Нийт дүн			51 236 000

---ooOoo---